

МОНГОЛ ДАХЬ АНУ-ЫН АШИГ СОНИРХОЛ БА ХӨРШ ГҮРНҮҮДИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

*Л.Оюунгэрэл**

Монгол улсын газар зүйн өвөрмөц байрлал эрт дээр үеэс их гүрнүүдийн сонирхлыг татсаар иржээ. Өнгөрсөн зуунд Монгол нь хөрш хоер их гүрэн - хуучин ЗХУ, Хятад улстай харилцан үйлчлэлд оршиж, ‘хүйтэн дайны’ үеийн бартаат замыг туулж, харилцааны багагүй туршлага хуримтлуулсан билээ.

XXI зуунд хүн төрөлхтөний хөгжил дэвшил өнгөрсөн зуунтай харьцуулахад зарим талаар бүр ч нарийн түвэгтэй, глобаль шинжтэй сорилтуудтай тулгарах нь одооноос ажиглагдаж байна. Даяарчиллын үед техник, технологийн хөгжил дэвшлийн үр дүнд улс орнуудын хол, ойрын тухай ойлголтод ч өөрчлөлт орж байна. Тийм ч учраас Монгол нь хөрш хоер их гүрэн төдийгүй АНУ-ын сонирхлын хүрээнд багтах болжээ. Монгол дахь АНУ-ын ашиг сонирхлын хувьсал өөрчлөлтийг судлах нь манайд шинээр үүсэн хөгжиж байгаа америк судлалын нэг чухал чиглэл болж байна.

Сүүлийн жилүүдэд АНУ нь Монголын стратегийн ач холбогдол, тус улс дахь ашиг сонирхлоо илүү тодорхой томъёолох боллоо. 1998 оны 3-р сард АНУ, Монголын харилцааны асуудлаар АНУ-ын Сенатаас гаргасан тогтоол нь хэрэг дээрээ Монголын талаар АНУ-ын баримтлах хөтөлбөр байлаа. Ийнхүү 90-ээд оны дунд үеэс АНУ нь Монголыг “Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийн аюулгүй байдлын стратегидаа хамруулах” болжээ.¹ Энэхүү шинэ хандлага нь АНУ-ын эсрэг үйлдсэн 2001 оны 9-р сарын 11-ний террорист халдлага, Иракийн дайнаас хойш улам ч тодорхой болж байна.

Америкийн албан ёсны байгууллагуудын мэргэжилтнүүд Монголын стратегийн ач холбогдлыг юуны өмнө, газар зүйн байрлалын үүднээс авч үзэж: “цөмийн зэвсэгтэй хоер их гүрний дунд, мөн Умард Солонгос, Казахстантай ойр байрладаг” гэж тодорхойлж байна. Улс төр, эдийн засгийн хувьд бол “Монгол Улсын тогтвортой хөгжил Төв Ази ба Зүүн Хойд Азийн тогтвортой байдалд чухал хувь нэмэр болно” гэж үзэж байна.² Үүнийг иш үндэс болгон Монголын хувьд баримтлах **АНУ-ын стратегийн зорилтыг нэгдүгээрт, Эрч хүчтэй, цэцэглэн**

*Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хөгжих Монгол Улс нь хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхийн энэ хэсэгт тогтвортой байдлыг бий болгоно. Төв Азийн нэг талд Афганистан, нөгөө талд Монгол байрлажээ. Монгол Улс Орос, Хятад, Солонгос, Казахстанд ойр байрладаг, цаашдаа түүний стратегийн ач холбогдол улам тод харагдах болно. Энэ үүднээс авч үзвэл, тогтвортой, тусгаар тогтносон, ардчилсан Монгол улс нь терроризмын эсрэг бүх нийтийн тэмцэлд ч, энх тайванч, цэцэглэн хөгжих Ази тивийг бүтээн байгуулахад ч дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэгтэйгээр оролцох боломжтой. **Хоёрдугаарт;** хөгжлийн замдаа амжилт олноор Монгол нь бусад улсын хувьд улс төр, эдийн засгийн шинэтгэлийг нэгэн зэрэг өрнүүлж болохын үнэмшилтэй жишээ болно. Умард ба БНСУ-тай аль алинтай нь харьцаж ирсэн Монголын өвөрмөц харилцаа нь Умард Солонгосыг олон арван жилийн хаалттай, түгжигдмэл байдлаас гарахад “загварын” үүрэг гүйцэтгэж нааштай, бүтээлч хувь нэмэр оруулах боломжтой³ гэж үзэж байна.

Монгол дахь АНУ-ын эрх ашиг, сонирхол Монголын талаар баримтлах бодлогод нь тусгалаа олж сүүлийн жилүүдэд хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжлийнхөө шатанд орлоо. Монголын хувьд 90-ээд оноос хойш арав гаруй жилийн хугацаанд Монголын хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлыг бататгахад АНУ-ын үүрэг улам бүр чухал болж байна.

Сүүлийн үед Монгол, АНУ-ын харилцааны хөгжил, хэтийн төлөвийг манай хоёр хөрш - Орос, Хятад улсад шинжлэх ухаан, улс төрийн хүрээнийхэн анхааралтай судалж байна. Тиймээс Орос, Хятадын судлаачдын үзэл баримтлалын нийтлэг ба ялгаатай талуудыг сүүлийн үед хэвлэгдсэн зарим материалд үндэслэн тодруулахыг оролдоё.

Нийтлэг талууд:

1. Орос, Хятадын судлаач, улс төрчид Монголын газар зүйн байршлыг стратегийн хувьд чухал ач холбогдолтой гэсэн үзэж байгаа нь тэдний нийтлэг байр суурьтай байна. Монгол, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрч байгаад Оросын ч тэр, Хятадын ч улс төрийн бодлоготнууд, улс төрийн шийдвэр гаргахад нөлөө үзүүлдэг тэргүүлэх судалгааны байгууллагууд анхаарах ёстой хүчин зүйл гэж үзэж судалгаа, шинжилгээгээ гүнзгийрүүлж байна. Үүний нэг тод жишээ бол Монголын орчин үеийн байдлыг судалдаг эрдэм шинжилгээний тэргүүлэх байгууллага - ОХУ-ын Дорно Дахины Хүрээлэнгээс сүүлийн үед Монголын түүх, хөгжлийн асуудлаар нилээд олон бүтээл

хэвлүүлжээ. Түүнчилэн 2002 оны 8-р сард хуралдсан Олон улсын монголч эрдэмтний VIII их хурал дээр Оросын эрдэмтэд Г.С.Яскина, В.Ц. Ганжуров, А.С.Железняков нар Монголын гадаад бодлого, Оросын стратегийн сонирхлын асуудлаар тавьсан илтгэлдээ 90-ээд оноос хойш Монгол, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрч байгааг тэмдэглэжээ.

ХКН-ын Төв Хорооны Намын сургуулийн хэвлэлийн газраас 1998 оны 8-р сард хэвлүүлсэн “Зуун дамжсан Хятадын гадаад орчин хийгээд гадаад бодлогын стратеги” ном⁴, 2000 оны 8-р сард Тайваньд болсон “Сүүлийн 10 жилд Монголын улс төр, эдийн засгийн хөгжилд гарсан өөрчлөлтүүд ба хэтийн төлөв” нэртэй олон улсын бага хурал,⁵ Хятадын Батлан хамгаалах Их сургуулийн хэвлэлийн газраас 2002 оны 1 сард эрхлэн хэвлүүлсэн “Геополитик” номонд⁶ Монголтой холбоотой асуудлууд тодорхой хэмжээгээр тусгагджээ. Хятадын ЗХА-ийг судлах Хүрээлэнгийн “Зүүн Хойд Ази судлал” сэтгүүлийн 2002 оны №2-т Ван Хайся-гийн “Америк Монгол хөзрөөр тоглохоос сэрэмжил” өгүүлэлд Монгол, АНУ-ын харилцааг тусгайлан судалж бодлого боловсруулагчдадаа хандаж асуудал дэвшүүлсэн ажээ.⁷

2. Орос, Хятадын судлаачид:

- 90-ээд оноос хойш АНУ-аас Монголд үзүүлж байгаа тусламж;
- Монгол, Америкийн цэргийн салбар дахь хамтын ажиллагааны асуудалд дүн шинжилгээ хийж байна;
- Тэд Монгол, АНУ-ын харилцааг Монгол, Оросын ба Монгол, Хятадын харилцааны үүднээс авч үзэж, Монголтой тогтоосон өөр өөрсдийн улсын харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх шаардлагатайг тэмдэглэж байна.

Оросын улс төрийн хүрээнийхэн Монгол, Америкийн харилцаа гүнзгийрч байгааг тэмдэглэж энэ талаар санал бодлоо илэрхийлэх боллоо. 2003 оны 1-р сарын 22-нд Оросын Ерөнхийлөгч В.Путины удирдаж явуулсан Төрийн Зөвлөлийн гадаад бодлогын асуудлаарх хуралдаан дээр Чита мужийн захирагч Р.Ф. Гениатулин хил орчмын улсуудын талаар тавьсан сонголдоо Монгол, АНУ-ын харилцааны асуудлыг хөндөж: Ази, Номхон далайн бүс нутагт Орос улс идэвхтэй үйл ажиллагаа явуулахад Монгол Улстай тогтоосон эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагаа чухал гэж тэмдэглээд; харамсалтай нь Орос улс Монгол дахь урьдын улс төр, эдийн засгийн

байр сууриа Хятад, Өмнөд Солонгос, Японд алдаж байна. АНУ ч Монголыг ихэд сонирхож байна гэжээ. Монголын гадаад бодлого, эдийн засгийн стратегийг АНУ-ын Хөгжлийн Агентлагын шууд тусламжтай боловсруулж байна гээд Монголын талаар явуулж байгаа манай эдийн засаг, хүмүүнлэгийн бодлого идэвхгүй байгаа учраас бидний тооцоолж байгаагаар 10-15 жилийн дотор Монгол нь Оросоос улам бүр хөндийрч болзошгүй гэж тэмдэглэжээ.⁸

Хятадын улс төрчид ч Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны ач холбогдлыг онцлон тэмдэглэж байна. Иракт дайн эхлэхэд Монголын Засгийн газар АНУ тэргүүтэй холбоотны эвслийг дэмжсэн шийдвэр гаргасны дараахан БНХАУ-аас Монголд суугаа Элчин сайд Хуан Жакуй 2003 оны 3-р сарын 20-нд “Зууны мэдээ” сонинд өгсөн ярилцлагадаа: “Даяаршлын эринд манай хоёр орон хөндийрөх боломжгүй, нэг нэгнээ түшин хөгжихөөс өөр замгүй шүү дээ” гэж тэмдэглэсэн юм.⁹

Ялгаа, зөрүүтэй талууд:

1. Монгол, Америкийн харилцаа Орос, Хятадад хэрхэн хамаарах, ямар үр дагавартай байж болох талаар хийж байгаа дүгнэлтүүд өөр өөр байна. Монгол, Америкийн харилцаа гүнзгийрэх болсон шалтгааны талаар оросын эрдэмтэн Г.Я.Яскина “Монгол ба гадаад ертөнц” номондоо: “Монголын аюулгүй байдал нь Орос, Хятад хоероос ихээхэн хэмжээгээр хамааралтай байгаа учраас тус улс АНУ-тай цэргийн талаар хамтран ажиллахыг эрэлхийлэх болсон юм” гэжээ. Харин тус хоёр улсын цэргийн хамтын ажиллагааны онцлог бол Монгол нь гадаадын аливаа улсын цэргийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй юм гэжээ. Гэхдээ хоёр орны цэргийн салбар дахь хамтын ажиллагаа цаашдаа хэт нягт болсон тохиолдолд хоёр хөрш нь хил хязгаарынхаа аюулгүй байдлын талаар тодорхой хэмжээгээр санаа зовниж болно” гэжээ.¹⁰

Оросын улс төр, шинжлэх ухааныхны хүрээнд Монгол, Америкийн харилцааны хөгжилд бодитой хандах хандлага давамгайлж байна.

Гэвч цэргийнхэний дотор хэт эмзэглэх хандлага ажиглагдаж байгааг хэлэх хэрэгтэй. Оросын “Спецназ России” сэтгүүлийн 2002 оны №9-д Путиний гадаад бодлогыг Алтан Ордны үеийн Оросын бодлоготой харьцуулж, А.Невский Алтан Ордны хаанд мөргөж хүлцэнгүй байсны ачаар улс орон түр амсхийх боломжтой болсныг

дурьдаад одоо Орос “шүдээ зуугаад ч хамаагүй” Америкийн ивээлд нь багтаж төрөө төвхнүүлэх хэрэгтэй байна гэжээ. Харин Америкчуудтай холбоотон болсон Гүржийн хувьд цэргийн цохилт өгөх хэрэгтэй гэжээ.¹¹

Хятадын судлаач Ван Хайся-гийн дээр дурьдсан өгүүлэлд¹² Монгол, АНУ-ын харилцааг дагнан судалжээ. Монгол нь аль хэдийн Хятад, Америк, Орос гурван их гүрний гурвалжилсан харилцааны цөм болсон; Монголын геостратегийн байрлалыг Хятад, Америк, Орос зэрэг их гүрнүүд чухалчлан гадаад бодлогын түншээ болгохын төлөө өрсөлдөж байна гэсэн түүний дүгнэлт бодитой, шинэлэг юм. Асуудлыг өргөн хүрээнд авч үзсэн учраас Монголын талаар дээрх гурван их гүрний баримталж байгаа байр суурийг харьцуулан авч үзжээ. Судалгааны энэ хандлага цаашдаа чухал гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Судалсан арга зүйн хувьд шинэлэг боловч судлаачийн зарим үзэл баримтлал, хийж байгаа дүгнэлтүүдэд шүүмжлэлтэй хандаж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тэр нь юуны өмнө:

1. “Түүхэнд Монгол нь Хятадын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг байсаар ирсэн” гэсэн дүгнэлт; (х.151);
2. Америкийн хүч нөлөө Монголд нэвтрэн орж буй нь түүний Хятадыг тогтоон барих стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм, Өнөөгийн олон улсын улс төр, эдийн засгийн байдлаас үзэхэд Хятад, Оросын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хийгээд Монголын бамбай бүсийн үүрэг нь салгаж болшгүй юм; Хэрэв Америкийн хүч нөлөө Монголд өргөжин өөд өөдөөсөө харан суухад хүрвэл Хятад-Америк, Орос-Америкийн шууд мөргөлдөх магадлал нэмэгдэх болно. Үүнээс үзэхэд Монголтой харилцаагаа бэхжүүлэн Монголын гадаад бодлогыг Америкийн тал руу хэт хэлбийхээс сэргийлэх нь Хятад, Оросын үндэсний аюулгүй байдлын нийтлэг хэрэгцээ шаардлага юм (х.151) гэж дүгнэжээ.
3. Хятад, Монгол хоёр орон бол үндэстэн нь хил дамнан оршдог бөгөөд энэ нь Хятадын нийгмийн тогтвортой байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын батлан хамгаалах аюулгүй байдалтай шууд холбоотой юм. АНУ үндэстний болон шашны асуудлыг дөрөөлөн гамшгийн үүд нээж Хятадын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохоос сэргийлэх хэрэгтэй юм гэжээ.

Хятадын судлаачийн дээрх дүгнэлтүүдийг тал бүрээс нь шүүмжилж болох боловч арга зүйн хувьд онцлон тэмдэглэх ёстой гол зүйл бол Монгол нь хэдийгээр жижиг улс боловч тусгаар тогтносон улсын хувьд дэлхийн бусад улс орнууд, түүний дотор их гүрнүүдтэй харилцахдаа өөрийн гэсэн үндэсний эрх ашгаа юуны өмнө урьдал болгож байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Зарим дүгнэлт

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус улс орнуудын ашиг сонирхлын тэнцвэрийн үзэл баримтлалд тулгуурласан ба Монгол, АНУ-ын харилцаа, цэргийн болон бусад салбар дахь хамтын ажиллагаа ч эл зорилгод нийцэж байгаа билээ. Харин Монгол, АНУ-ын харилцаа нь хоёр хөршөд сөрөг үр дагавар авчирч болзошгүй гэсэн болгоомжлол байгааг тооцож бүс нутаг дахь их гүрнүүдийн ашиг сонирхлын судалгааг гүнзгийрүүлэх шаардлагатай юм. Энэ талаар анхаарах ёстой нэг чиглэл бол Монгол, Орос, Монгол, Хятадын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа нь бүс нутагт байсаар байгаа “хүйтэн дайны” уур амьсгалыг эцэс болгоход чухал ач холбогдолтой юм. Монголын байгууллагуудын идэвхтэй оролцоо ч чухал болж байна. Бүс нутгийн хамтын ажиллагаа нь эрдэмтэн судлаачдын түвшинд бие биеийн үзэл баримтлалыг ойлгохоос бас нилээд хэмжээгээр шалтгаална гэдгийг хэлмээр байна.

Зүүлт

1. The United States Security Strategy for the East Asia - Pacific Region 1998, pp. Pentagon, Washington, p. 35, In: Udo Barkmann, Mongolian Political and Economic Development During the Past Ten Years and Future Prospect, Aug 23 -24, 2000, International Conference, Taipei, Taiwan, p. 166
2. USAID\Mongolia, Strategic Plan, 2004 - 2008, UB, Mongolia, May 2003, p.7
3. Ibid, pp.8-9
4. Жан Зи. Зуун дамжсан Хятадын гадаад орчин хийгээд гадаад бодлогын стратеги, ХКН-ын Төв Хорооны Намын сургуулийн хэвлэлийн газар, 1998 оны VIII сар: Стратеги судлал, 2002 №2-3 -д үз

5. Mongolian Political and Economic Development During the Past Ten Years and Future Prospect, Aug 23-24, 2000, Taipei, Taiwan
6. Дун Лянцин. Геополитик, Батлан Хамгаалах Их Сургуулийн хэвлэлийн газар, 2002 оны 1 сар: Стратеги судлал, 2002 оны №2-3-д үз
7. Стратеги судлал, 2002 №2-3 -х.143-156
8. Международная жизнь, 2003 оны №3, х. 25-26
9. Зууны мэдээ, 2003 оны 3 сарын 20
10. Яскина Г.С. Монголия и внешний мир, М, 2002, с.247
11. Константин Крылов. Отыгрыш, Спецназ России, 2002, №9 цит по: Новый мир, 2003, №1, с.228
12. Ван Хайся. Америк монгол хэзрөөр тоглохоос сэрэмжил, Стратеги судлал, 2002, №2-3, х. 143-157